БАТЛАВ
“БУЛГАН МЭЭЖ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ГАНБААТАР

Техникийн нөхцөл олгох комиссын 2025 оны
4 дугаар сарын 22-ний өдрийн хурлын 04 тоот
хурлын тэмдэглэлийг үндэслэн зөвшөөрөв.

Техникийн нөхцөл №202519

1.	**Барилга байгууламжийн нэр, зориулалт, байршил**	**Нэр:”**Нэгдсэн Эмнэлэг” Шинэ барилга 5-н блок **Байршил:**Булган аймаг, Булган сум 6-р баг Л.Энэбишийн гудамж 1-101
2.	**Нийт усны хэрэглээ:**	Дулааны ачаалал 0,727 гкал/ц Цэвэр усны 42,0 м.куб/хон Технологийн усны 6,75 м.куб/хон Галын усны 5 л/с Бохир усны 42,0 м.куб/хон
3.	**Дулаан, Цэвэр усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр, Хотын шугам сүлжээний усны даралт:**	Хотын усны даралт-2,5 ата .....-р ДХ-аас Цэвэр усны шугам –Ф100 мм Дулааны шугам өгөх- Ф 125 мм Дулааны шугам буцах- Ф 125 мм Хэрэглээний шугам өгөх- Ф 65 мм Хэрэглээний шугам буцах- Ф 50 мм
4.	**Бохир усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр:**	БУХ-..... дугаар худгаас Ф219 мм шугамаар ариутгах татуургын холболт хийх.
5.	**Нэмэлт нөхцөл:**	**Ус хангамж:**MNS ISO 4064-2:2013 Битүү шугам хоолой дахь усны зарцуулалтын хэмжилт. Ундны хүйтэн ба халуун усны тоолуур. Суурилуулахад тавих шаардлагыг ханган ажиллах. **Ариутгах татуурга:**Ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ, барилга байгууламж БНбД 40-04-16 ханган ажиллах. **Дулаан хангамж:**Дулааны сүлжээ БНбД 41-02-13, Дулааны сүлжээ БНбД 41-05-18 ханган ажиллах. Дулааны ачаалалдаа тохирсон дулааны тоолуур суурилуулах. • Аймгийн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний дэд хөтөлбөрүүдтэй уялдуулах • Газрын тухай хууль тогтоомжтой нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллах • Дээрх арга хэмжээ зөрчигдсөн тохиолдолд дахин зөвшилцөх
6.	**Анхаарах зүйлс:**	• Архитектур төлөвлөлтийн даалгавар, хавсралтын даалгавар • Барилгын эскиз зураг • Техникийннөхцлийнхүчинтэйхугацаа 2 жил • Огтолгоог ”Булган Мээж” ХХК-аар хийлгэх
7.	**Объект барих дээд газрын шийдвэр**	Булган аймгийн ГХБХБГазар.
8.	**Хэрэглэгчийн нэр, утас :**	“Нэгдсэн Эмнэлэг” Шинэ барилга 70342757
9.	**Техникийн нөхцөлтэй холбогдсон схем зураг:**	Тийм

Булган сумын 6-р багт шинээр төлөвлөж буй Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын төлөвлөлтийн байршлын тойм зураг.
№ 07

Хаяг: Булган аймгийн Булган сум

2025.04.22

ЗӨВШӨӨРСӨН

Булган аймгийн Засаг дарга	Д.Пүрэв-Очир
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга	У.Бямбасүрэн
ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга	Б.Ганзориг
Аймгийн ерөнхий архитектор	М.Цэрэнчимэд
Онцгой байдлын газрын дарга, хурандаа	Н.Хишигдорж
"Булган Мээж" ОНӨХХК-ийн Ерөнхий инженер	Э.Нямсүрэн
"Мэдээлэл холбоо сүлжээ" Булган салбарын ерөнхий инженер	Д.Ням-Осор
"Эрдэнэт Булган цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Ахлах инженер	Г.Лхагважаргал
Булган сумын Засаг дарга	Д.Бямбажаргал
Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга	Б.Шижирбаатар
Хянасан: ГХБХБГ-ын КАХМэргэжилтэн	Н.Отгонжаргал
Боловсруулсан: ГХБХБГ-ын ИДБАХ Мэргэжилтэн	Г.Батцагаан

Байршлын тойм зургийг 2 хувь үйлдсэн бөгөөд нэг хувийг хүсэлт гаргарч талд, нэг хувийг ГХБХБГ-т тус тус хадгална.

Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 25 дугаар зүйлийн 25.5, 25.6 заалтын дагуу Барилга байгууламжийн ажил дууссаны дараа гүйцэтгэлийн геодизийн хэмжилт хийлгэж ГХБХБГ хүлээлгэж өгнө.

Тайлбар:

1. Шинээр төлөвлөж буй Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга
2. Нэгдсэн эмнэлэг
3. 50 ортой төрөх эмнэлэг
4. Булган сумын 2-р цэцэрлэг

Одоо байгаа бохирын шугам
Төлөвлөж буй бохирын шугам
Одоо байгаа холбооны кабель
Одоо байгаа дулаан, цэвэр усны шугам
Төлөвлөж буй дулаан, цэвэр хэрэгцээний халуун усны шугам
Царилгааны агаарын шугам
Цахилгааны кабель шугам

МАШСТАБ 1:2000

Барилга, байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэхдээ Газрын тухай хуулийн 48 дугаар зүйл, 56 дугаар зүйл, Монгол улсын Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл, 16 дугаар зүйл, 37.7 дугаар зүйл, 40.1.10 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 213 тоотоол, 2021 оны 212 тоотоол тавих шаардлагуудыг мөрдлөг болгон ажиллах. Зөвшилцөх байршлын тойм зураг дээрх мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар гарын үсэг зурууллж шаардагдах бичиг баримтыг бүрдүүлсний дараа ГХБХБГазраас барилга, байгууламж эхлүүлэх зөвшөөрөл авч ажлыг эхлүүлнэ. Анхаарулах нь: Байршлын тойм зурагтай холбоотой санал хүсэлтийг ГХБХБГ-т албан тоотоор ирүүлнэ. Тухайн зөвшилцөх байршлын тойм зураг нэг жилийн хугацаанд хүчинтэй болно.

MONGOLIA NETCOM

ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

БАТЛАВ
"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ХХК -ийн
БУЛГАН АЙМГИЙН ГАЗРЫН ДАРГА
Ч.ОЮУН

Техникийн нөхцөл

Дугаар: ТН-2025/05 огноо: 2025.04.21

Захиалагч байгууллага: БУЛГАН АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

Хэрэглэгчийн нэр: БУЛГАН АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

Харилцах утас: 70342757

Байршил: Булган аймаг Булган сум

Зориулалт: Эмнэлэгийн барилга

Холбооны хэрэгцээ: Интернэт сүлжээ /шилэн кабель/

1. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах Хороноос хорооноос олгогдсон харилцаа холбооны үндсэн сүлжээ байгуулах эрхийнхээ дагуу техникийн нөхцлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгоно. Техникийн нөхцөлгүйгээр холбооны худаг сувагчлал байгуулах, кабель татах, шилжүүлэх тохиолдолд уг барилга обьектыг техникийн комисс болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

2. **Техникийн үндсэн нөхцөл:**

Шинээр хийгдэх холбооны кабель шугамын трассыг сонгохдоо аймгийн ГХБХБГазартай зөвшилцөж сонгоно.

2.1 ***Шилэн кабель*:** Одоо байгаа эмнэлэгийн шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжөөс шинээр баригдах эмнэлэгийн барилга руу шилэн кабель татаж төгсгөлийн төхөөрөмжийг суурилуулна. Шинээр баригдах эмнэлэгт холбосны тоног төхөөрөмж байрлуулах өрөө төлөвлөх

3. **Зураг төсөлд зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:**

3.1 Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2013, MNS 5279:2013, MNS 5280:2003, MNS 6668:2017, MNS 6581:2016, MNS 3966:2017, MNS 6305:2012, MNS 4908:2017, MNS 5532:2005 ерөнхий шаардлагууд болон "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 5-р зүйлд заасны дагуу гүйцэтгэх.

3.2 Хэрэглэгчийн шугамын угсралтын ажил барилгын зураг төсөвт байхгүй болон хийгдээгүй бол захиалагчид мэдэгдэж зураг төсөвт оруулах.

3.3 Кабелийн хуваарилах хайрцагны байрлалыг хэрэглэгчийн шугамын нягтралын цэгт болон техник ашиглалтын шаардлага хангахуйц байдлаар сонгон суурилуулахаар технологийн норм хэмжээг зааж оруулах.

3.4 Дээрх техникийн нөхцлийн дагуу ажлын зураг гүйцэтгэхдээ тухайн ашиглалт хариуцсан газар нэгжээр техникийн шийдлийг хянуулан, зөвшилцөж батлуулна. (Утас:91082088

4. **Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:**
   4.1 Угсралт суурилуулалтын ажлыг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэнэ.
   4.2 Техникийн нөхцөл, ажлын зураг төсвийн дагуу угсралтын ажил эхлэхээс өмнө Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн ашиглалт хариуцсан газар, нэгжээс ажил эхлэх зөвшөөрлийг авч тухайн ашиглалт хариуцсан газар, нэгжийн хяналтан дор гүйцэтгэнэ.
   4.3 Газар шорооны ажил гүйцэтгэхдээ тухайн харъяалагдах газар нэгжээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актанд хавсаргах.
   4.4 Шинээр татсан кабель болон кробканд тэмдэглэгээг бүрэн хийсэн байх.
   4.5 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулж ажиллах.
   4.6 Хэрэглэгч холбох нөхцлийг бүрдүүлэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол Улсын стандарт MNS 6581:2016 ерөнхий шаардлагын дагуу гүйцэтгэнэ.
   4.7 Шинээр хийгдсэн худаг сувагчлалын байгууламжийг "Шугам сүлжээний гүйцэтгэлийн зураглалыг шалгаж хот байгуулалтын мэдээллийн санд хүлээн авсан акт", CD-ний хамт ашиглалтын байгууллагад хүлээлгэж өгсний үндсэн дээр худаг сувагчлалын гүйцэтгэлийн зургийг гаргуулна.
5. **Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:**
   5.1 Шинээр босгох агаарын баганын эргэлт бүр тулгууртай байна.
   5.2 Шинээр суурилуулсан холбооны кабель шугам болон худаг сувагчлалын байгууламжийг гүйцэтгэлийн актаар хүлээлгэн өгснөөр цаашид гарах засвар үйлчилгээг МХС ХХК нь хариуцна.
   5.3 Уг сувагчлалын трассыг цааш нь үргэлжлүүлэх болон шинээр кабель татах боломжийг хангах.
   5.4 Худаг сувагчлалд техникийн ашиглалтыг хоногийн ямар ч үед ажил үйлчилгээг шуурхай гүйцэтгэх боломжоор бүрэн хангах.
6. **Техникийн нөхцлийг** Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 04 сарын 18-ны өдрийн 01/260 тоот албан бичиг, хүсэлтийг үндэслэн техникийн нөхцлийг олгов.

7. Угсралтын ажил дууссаны дараа Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний хариуцсан нэгжээр хэмжилт шалгалт хийлгэж, техникийн актаар хүлээлгэн өгснөөр сүлжээнд холбогдох боломжтой.
8. Энэхүү техникийн нөхцөл нь батлагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна. Техникийн нөхцлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгалтыг олгоно.

Техникийн нөхцлийг хянан
баталгаажуулсан:
Ерөнхий инженер ..... Д.НЯМ-ОСОР

Боловсруулсан:
Кабель Шугамын Инженер ..... Н.ДОРЖПАЛАМ

“Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг”-ийн шинэ барилгын цахилгаан хангамж

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо: 2025.06.05 №83/2025 Улаанбаатар хот

1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг	Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг Булган аймаг, Булган сум, 6-р баг Булган, Л.Энэбиш-1 гудамж
2. Техникийн нөхцөл хүссэн байршил	Булган аймаг, Булган сум
3. Ажил үйлчилгээний зориулалт	Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн цахилгаан хангамж
4. Техникийн нөхцөл олгох, сунгах үндэслэл	4.1 Аж ахуйн нэгжийн газар ашиглах 06301-2018/00344 дугаартай гэрчилгээ, 4.2 Улсын бүртгэлийн 0000088944 дугаартай гэрчилгээ, 4.3 Булган аймгийн ерөнхий архитектор баталсан 2024 оны 10 дугаар сарын 09-ний АТД 14/2024 архитектур төлөвлөлтийн даалгавар, 4.4 Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн www.itc.energy.mn цахим системээр гаргасан хүсэлт, 4.5 Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн 2025 оны 05 дүгээр сарын 13-ны өдрийн 02/300 тоот албан бичиг,
5. Олгосон чадал	5.1 1000 кВА
6. Шугам сүлжээнээс хангах чадал	6.1 2027 онд 350 кВА 6.2 2027 оноос хойш нэмэгдэх ачааллыг эх үүсвэрийн нөөц, өвлийн их ачаалал, шугам сүлжээний горим ажиллагаатай уялдуулан, үе шаттай шийдвэрлэнэ,
7. Тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага	7.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орж, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх. 7.2 RS-485-ийн гаралтын интерфэйстэй олон улсын IEC61107, IEC62056 холболтын стандартуудын шаардлага хангасан байх, 7.3 Санах ой бүхий 0.2 нарийвчлалтай бүрэн электрон тоолуур суурилуулах. 7.4 Шинээр суурилуулж буй тоолуурууд нь тоолуурын нэгдсэн системд холбох. Мэдээлэл дамжуулах боломжийг бүрдүүлсэн байх. 7.5 Тоолуур, хянах, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангагч байгууллага

	“ЭБЦТС”-иас авах. Ажлын зураг төсөл боловсруулах шатанд суурилуулах тоолуурын төрөл, марк, схемийг тухайн байгууллагаар хянуулсан байх,
8. Гүйдлийн трансформаторт тавигдах шаардлага	8.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх. 8.2 Холбогдох тооцооны дагуу ачаалал хэрэглээнд тохирсон коэффициент бүхий гүйдлийн трансформатор суурилуулах. 8.3 Олон улсын IEC 61869-2 стандартын шаардлагыг хангасан, реле хамгаалалт, хэмжүүр, хянах хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг бүрэн хангасан, 0.2 нарийвчлалтай гүйдлийн трансформатор суурилуулах,
9. Холбогдох цэг	9.1 110/35/10 кВ-ын Булган дэд станц ЗРУ 10 кВ ХБ-ийн секц-1 болон секц-2 тус бүрт 10 кВ-ын вакуум таслуур, микропроцессорын реле хамгаалалт бүхий 2 гаргалгаа шинээр тоноглож 2*1000кВА чадалтай 10/0.4кВ-ын ХТП дэд станцыг тэжээх
10. Дамжуулах, түгээх сүлжээний шугам, дэд станцыг өргөтгөх шаардлага	10.1 Шинээр баригдах барилга байгууламжуудын цахилгаан хангамжид хэрэглээ, ачаалалд тохирсон 10/0.4 кВ-ын дэд станц /ХТП/ барьж, цахилгаан эрчим хүчээр хангах. Зураг төсөл боловсруулах шатанд холболтын схем, горим ажиллагааг ашиглагч байгууллага “ЭБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх, батлуулах, 10.2 10 кВ-ын хос кабель шугамын хөндлөн огтлол, 10/0.4 кВ-ын дэд станц /ХТП/-ын трансформаторын хүчин чадлыг хэрэглээ ачаалалтай уялдуулан тооцоогоор сонгож, Зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага “ЭБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх, батлуулах, 10.3 Дэд станцын 10/0.4 кВ-ын трансформаторууд нь хүчдэл тохируулгын 5 шатлал бүхий олон улсын IEC 60076-10 стандартын шаардлагыг хангасан байх, 10.4 Хуваарилах байгууламж, дэд станцын 10 кВ, 0.4 кВ-ын оруулга, гаргалгааны шугам, тоноглолуудад олон улсын стандартын шаардлага хангасан байх ба зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага “ЭБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх, 10.5 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи

	бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу ■10%-ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах, 10.6 Хуваарилах байгууламж, дэд станцуудад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 339 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-д заасны дагуу галын аюулгүй байдлыг хангах, 10.7 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх, 10.8 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага “ЭБЦТС” ТӨХК-уудад хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах,
11. Реле хамгаалалт, автоматикийн байгууламжид тавих шаардлага	11.1 Энэхүү техникийн нөхцлийн дагуу суурилуулах реле хамгаалалт, автоматикийн тоног төхөөрөмжүүд, удирдлага, хяналт, мэдээллийн системүүд нь “Бодлогын бичиг баримт батлах тухай” Эрчим хүчний сайдын 2019 оны 335 дугаар тушаалаар батлагдсан “Реле хамгаалалт, системийн автоматикийн талаар баримтлах бодлогын баримт бичиг”, “Эрчим хүчний салбарт баримтлах мэдээллийн технологийн бодлогын баримт бичиг”-шаардлагуудыг бүрэн хангах, хангагч байгууллага ЭБЦТС ТӨХК-тай зураг төсөл боловсруулах шатанд зөвшилцсөн байх. 11.2 Хуваарилах байгууламж, шугам, дэд станцын оруулга, гаргалгааны тоноглолуудад олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох богино залгааны тооцоонуудыг хийж, ашиглагч байгууллага ЭБЦТС ТӨХК-тай зөвшилцөн сонгох. 11.3 Реле хамгаалалт автоматикийн тавилын тооцоог хангагч байгууллага ЭБЦТС ТӨХК-уудаар хийлгэх.
12. Реактив чадлын зохицуулалт	-
13. Цахилгаан эрчим хүчний чанарыг хянах хэрэгсэл, чанарын үзүүлэлтийг тогтворжуулах төхөөрөмжийн хэрэгцээ	-
14. Нэг маягийн зураг	14.1 Зургийн даалгаврыг эрх бүхий

төсөл хэрэглэх зөвлөмж	байгууллагаас авах. 14.2 Ажлын зураг төсөл боловсруулахдаа Монголын Засгийн 2019 оны 108 дугаар тогтоолын 5 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллага болон ашиглагч байгууллага ЭБЦТС ТӨХК-тай зөвшилцсөн байх. 14.3 Зураг төсөл боловсруулах шатанд холболт хийх цэг, ячейкны дугаар, шуурхай ажиллагааны нэр, зарчимын схем, хоёрдогч хэлхээний зургийг ашиглагч байгууллага ЭБЦТС ТӨХК-тай зөвшилцөх.
15. Гэнэтийн гэмтэл саатал, аваарийн үед ашиглах бэлтгэл тэжээл, бие даасан цахилгааны үүсгүүр суурилуулах шаардлага	Эмнэлэг нь 1-р зэрэглэлийн хэрэглэгч тул аваарийн нөөцөд ачаалалд тохирсон чадалтай дизель үүсгүүр суурилуулах. Цахилгаан хангамж тасалдсан тохиолдолд хэрэглэгчийн өмч хөрөнгөнд ноцтой хохирол учирч болох онцлогтой хэрэглэгч дизель цахилгаан үүсгүүртэй байх ба автомат асаалтын систем болон АВР-тэй байна. Уг нөөц эх үүсгүүр нь хүчдэл тасарсан тохиолдолд эргэх хүчдэл орж ирэх боломжгүй байдлаар нэмэлт сэлгэн залгах, салгах бүхий тоноглол тавигдсан байна.
16. Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүйн ажиллагааны байдал	16.1 “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.8 “Өөрийн эзэмшлийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах” гэж заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнгын үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх. 16.2 “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.13 “Нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх гэж заасны дагуу хангагч байгууллага ЭБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх.
17. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа	17.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.9-д заасны дагуу /2 жилийн хугацаанд/ хүчинтэй. 17.2 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.13-д заасны дагуу техникийн нөхцөлийн дагуу зураг төслийн байгууллагаар хийлгэж, холбогдох байгууллагаар хянуулж, эрх бүхий

байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

17.3 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгуулахдаа хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.16-д заасны дагуу баталгаажуулсан зураг төслийг ирүүлнэ. Хэрэв баталгаажуулсан зураг төсөл ирүүлээгүй тохиолдолд техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгахгүй.

18. Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам

18.1 Дэд станц, цахилгаан дамжуулах шугамын байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, тухайн орон нутгийн газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн газраар батлуулан, мэдээллийн санд оруулсан байх,

18.2 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад трассын дагуу дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээх зардлыг төсөвт тусгах,

18.3 Шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах, угсралт, туршилт, тохируулгын ажлыг “Цахилгаан байгууламжийн угсралтын дүрэм” (2003 он), Эрчим хүчний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх “Тусгай зөвшөөрөл” бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх,

18.4 “Эрчим хүчний тухай” хуулийн 29.1.9 “Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй” гэж заасны дагуу өөрийн тоноглолоос хангагч байгууллагын зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.

19. Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох заалт

19.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.16, 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.

-2.16 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд холболт хийгдээгүй тохиолдолд хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ энэ дүрмийн 2.13-д заасан баталгаажуулсан зураг төслийн хамт техникийн нөхцөл олгосон байгууллагад ирүүлнэ.

-2.17 дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

-2.17.1. хүчинтэй хугацаа дууссан;

-2.17.2. техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу

тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;
-2.17.3. холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн;
-2.17.4. дамжуулагчаас санал аваагүй, өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцөлд заагдсан хүчин чадлаас хэтрүүлсэн.
19.2 Олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд